

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019.10.22-ны өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрээс:

9.1. Дундговь аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд явуулсан биелэлтийн шалгалтын дүнгийн тухай хэлэлцээд дүнг 91,0 хувийн үнэлгээтэй батлав.

9.2. Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд явуулсан биелэлтийн шалгалтын дүнгийн тухай хэлэлцээд дүнг 73,0 хувьтай батлав.

9.3. Төв аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд явуулсан биелэлтийн шалгалтын дүнгийн тухай хэлэлцээд дүнг 88,3 хувийн үнэлгээтэй батлав.

9.4. Завхан аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд явуулсан албаны шалгалтын дүнтэй танилцав.

9.5. Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд явуулсан албаны шалгалтын дүнтэй танилцав.

9.6. “Уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам”-ын төслийн тухай хэлэлцээд холбогдох засвар, өөрчлөлтийг тусган 10 дугаар сарын 23-ны дотор Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулахыг даалгав.

9.7. “Нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх заавар”-ын төслийн тухай хэлэлцээд Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалын хавсралтаар 10 дугаар сарын 25-ны дотор батлуулахыг даалгав.

9.8. “Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журам”-ын төслийн тухай хэлэлцээд ажлын хэсгийг өргөн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж, энэ оны хамгийн сүүлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах үүрэг өгөв.

9.9. “Онцгой байдлын байгууллагын тусгай зориулалтын автомашины техникийн шаардлага” байгууллагын стандартыг шинэчлэн батлах тухай хэлэлцээд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулан, Стандарт хэмжилзүйн газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

9.10. “Гамшгаас хамгаалах цагаан ном”-ын бүтэц, агуулга болон хэвлүүлэх зардлыг батлуулах тухай хэлэлцээд Олон нийттэй харилцах төвийн Хэвлэх хэсэгт 500 ширхэгийг англи, монгол хэлээр хэвлүүлэхээр шийдвэрлэв.

9.11. Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2019 оны III улирлын байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд шалгалт явуулах 5 ажлын хэсгийг 11 дүгээр сарын 10-30-ны өдрүүдэд ажиллуулж, дүнг 12 дугаар сарын 15-ны дотор даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулах,

- Зүүн бүсийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах ажлын хэсгийг ирэх 7 хоногт багтаан явуулахаар шийдвэрлэв.

9.12. Давтан сургалт, сэргээн заслын төвийн тохижилтийн ажлын явцын талаар танилцуулав.